



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 08 сарын 15 өдөр

Дугаар А/16

Сүхбаатар сум

┌ Аудитын тайлан баталгаажуулах тухай ┐

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/102 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын дөрөвдүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл”-д хийсэн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Нийцлийн аудитын газар болон аймгийн Сонгуулийн хорооны дарга (Ө.Сувдаа) нарт тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ, авч биелэлтийг тогтоосон хугацааны дотор ирүүлэхийг аймгийн Сонгуулийн хорооны дарга (Ө.Сувдаа)-д зөвлөсүгэй.
4. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (аудитор Ж.Баясгалан)-т үүрэг болгосугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын баг (аудитор Ж.Баясгалан)-т даалгасугай.



Б.БАТМӨНХ

С:/Бичиг хэрэг/2025/Тушаал.Досх

432501045

# НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ ДҮҮРГИЙН ИТХ-ЫН 2025 ОНЫ НӨХӨН  
СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН УЛСЫН ТӨСВӨӨС  
САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

АУДИТЫН КОД: СЭА-2025/117-ШТА-НА

АЙМАГ, СУМДЫН СОНГУУЛИЙН ХОРОО НЬ БАТЛАГДСАН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТЫН  
ДАГУУ ЗАРЦУУЛЖ, 12,127.2 МЯНГАН ТӨГРӨГИЙН ХЭМНЭЛТИЙГ БУЦААН  
ТӨВЛӨРҮҮЛСЭН БАЙНА.

Сүхбаатар сум

**Дарга, тэргүүлэх аудиторын үүргийг түр орлон  
гүйцэтгэгч Б.Батмөнх**

Утас: 70363040 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

**Аудитор Ж.Баясгалан**

Утас: 70362442 Цахим хаяг: bayasgalanj@audit.gov.mn

**Аудитор Э.Энхбүрэн**

Утас: 70362442 Цахим хаяг: enkhburene@audit.gov.mn

2025 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой мэдээллийг  
дараах хаягаар авна уу: Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

## **АГУУЛГА**

Товчилсон үгийн тайлбар

Хүснэгтийн товьёг

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Ерөнхий мэдээлэл

**Бүлэг 1. Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгийг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх?**

1.1. Сонгогчийн тоо, сонгууль зохион байгуулахад оролцох ажилтны тоо, сум, хэсгийн хороодын тоо зэрэг мэдээлэлд үндэслэн зардлын төсвийг хуваарилсан байна.

1.2. Сонгуулийн хорооны төсвийг төлөвлөсний дагуу олгосон байна.

1.3. Сонгогчийн болон итгэмжлэгдсэн ажилтны тоо, сумдын байршил зэрэг мэдээлэлд үндэслэн зардлын төсвийг хуваарилсан байна.

**Бүлэг 2. Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх?**

2.1. Аймаг, сумдын сонгуулийн хороо нь Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлаас **12,127.2** мянган төгрөгийг хэмнэсэн байна.

2.2. Зардлын гүйцэтгэлийг СЕХ-ноос баталсан журмын дагуу тайлагнасан байна.

2.3. Аймгийн сонгуулийн хорооноос сумын болон хэсгийн хороодод төсвийн зарцуулалт, тайлагналын талаар сургалт хийж, зөвлөмж хүргүүлсэн байна.

## **АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ**

### **ДҮГНЭЛТ**

### **ЗӨВЛӨМЖ**

### **САНАЛ**

## Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МТБ	Мэдээлэл технологийн баг
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
НАГ	Нийцлийн аудитын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
АСХ	Аймгийн сонгуулийн хороо
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

## Хүснэгтийн товъёг:

*Хүснэгт 1. Сэлэнгэ аймагт хуваарилсан санхүүжилт*

*Хүснэгт 2. Аймгийн сонгуулийн хорооноос хуваарилсан санхүүжилт /зардлын нэр, төрлөөр/*

*Хүснэгт 3. Аймаг, сумдын сонгуулийн хороонд олгосон санхүүжилт*

*Хүснэгт 4. УБЕГ-аас аймгийн УБХ-т хуваарилсан санхүүжилт*

*Хүснэгт 5. Аймаг, сумдын сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэл /аймаг, сумдаар/*

*Хүснэгт 6. УБХ-ийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл*

*Хүснэгт 7. Сонгуулийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл /зардлын нэр төрлөөр/*

## **АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ**

### **Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:**

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны "Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай" А/108, 2025 оны А/44 дүгээр тушаал, Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны "Гүйцэтгэлийн төлөвлөгөө"-г үндэслэн Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийв.

### **Аудитын зорилт:**

Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, аудитын тайланг ҮАГ-ын НАГ, аймгийн сонгуулийн хороо, УБХ болон холбогдох бусад байгууллагад хүргүүлж, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Үүнд:

- *Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх;*
- *Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс олгосон санхүүжилтийг зориулалтын дагуу, арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх.*

### **Аудитын хамарсан хүрээ:**

Аудитад аймаг, сумдын сонгуулийн хороод, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс зэрэг байгууллагуудыг хамрууллаа.

### **Аудитын арга зүй:**

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 "Төрийн аудит. Тулгуур зарчим", MNS 6817-5:2020 "Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын зарчим", MNS 6817-7:2020 "Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит", MNS 6817-8:2020 "Төрийн аудит. Нийцлийн аудит"-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам", түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан "Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал"-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

### **Аудитын шалгуур үзүүлэлт:**

Аудитад асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүйтэй холбоотой дараах хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль;
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль;
- Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тогтоол;
- СЕХ-ны даргын 2025 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн А/33 захирамжаар шинэчлэн баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”;
- СЕХ-ны Тамгын газрын даргын 2025 оны А/18 дугаар тушаалаар баталсан “Аймаг нийслэл сум, дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуулийн Сэлэнгэ аймгийн сонгуулийн хорооны төсөв”;
- Холбогдох бусад хууль эрхийн актууд.

#### **Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:**

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, аудитор Э.Энхбүрэн, Ж.Баясгалан нар 2025 оны 07 дугаар сарын 04-өөс 08 дугаар сарын 15-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

#### **ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:**

Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуулийг 6 дугаар сарын 22-ны өдөр Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулсан байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 176 дугаар тогтоолоор аймгийн сонгуулийн хороог 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан бол сумдын сонгуулийн хорооны тогтоолоор сонгуулийн хороог тус бүр 5-7 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан байна.

Аймгийн сонгуулийн хороонд 7, нягтлан бодогч болон бичиг хэргийн 2, сумдын сонгуулийн хороонд 39, хэсгийн хороодод 86, мэдээллийн технологийн 22 даамал, цагдаагийн байгууллагын ажилтан 11, тагнуул 1, улсын бүртгэлийн ажилтан 10 зэрэг нийт 178 төрийн албан хаагч ажилласан байна.

СЕХ-ноос аймгийн сонгуулийн хороонд **190,203.8** мянган төгрөгийн төсөв хуваарилж, санхүүжилтийг бүрэн олгосон байна.

УБЕГ-аас нэрсийн жагсаалт хэвлэх, санал авах техник хэрэгслийг тээвэрлэх болон түүнтэй холбогдсон албан хаагчийн сургалт зохион байгуулах болон мөнгөн урамшуулал, унаа, хоолны зардалд нийт **12,687.5** мянган төгрөгийг Сэлэнгэ аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст хуваарилсан байна.

**БҮЛЭГ 1. АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ ДҮҮРГИЙН ИТХ-ЫН 2025 ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬД УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, ХУВААРИЛСАН БАЙНА.**

**1.1. Сонгогчийн тоо, сонгууль зохион байгуулахад оролцох ажилтны тоо, сум, хэсгийн хороодын тоо зэрэг мэдээлэлд үндэслэн зардлын төсвийг хуваарилсан байна.**

**1.1.1** Сэлэнгэ аймагт 2025 оны Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын нөхөн сонгуулийг зохион байгуулахад улсын төсвөөс олгох зардлын хэрэгцээ шаардлагыг сонгогчийн тоо, сонгууль зохион байгуулахад оролцох ажилтны тоо, сум болон хэсгийн хорооны тоо, тэдгээрийн байршил, хоорондын зай зэрэг бусад шаардлагатай мэдээлэлд үндэслэн тодорхойлж, төсвийг хуваарилсан байна.

**1.1.2** Дээрх үзүүлэлтүүдийг үндэслэн хэсгийн хорооны гишүүдийн урамшуулал, хоол, унааны зардал, мэдээ дамжуулах зардлыг тооцоолж, төлөвлөсөн бол бичиг хэрэг, сургалт сурталчилгаа, шуудан холбооны зардлыг тогтмол байхаар тооцож, ирүүлсэн байна.

**1.2. Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуулийн хорооны төсвийг төлөвлөсний дагуу олгосон байна.**

**1.2.1** СЕХ-ноос аймгийн сонгуулийн хороонд 3 удаагийн санхүүжилтээр нийт **190,203.8** мянган төгрөгийн санхүүжилтийг хуваарилсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

**Хүснэгт 1. Сэлэнгэ аймагт хуваарилсан санхүүжилт**

*/мянган төгрөг/*

№	Зардлын нэр төрөл	2025.04.28	2025.05.23	2025.06.16	Нийт
1	Сонгуулийн дүн мэдээний маягт, албан бичгийн хэвлэмэл хуудас, үнэмлэх хэвлүүлэх зардал	336.0			336.0
2	Сургалтын зардал	1,425.0			1,425.0
3	Бичиг хэргийн зардал	3,150.0			3,150.0
4	Шуудан, холбооны зардал	4,200.0			4,200.0
5	Унааны зардал	11,440.0	6,038.0		17,478.0
6	Санал авах байр бэлтгэх зардал		3,000.0		3,000.0
7	Сурталчилгааны зардал		7,000.0		7,000.0
8	Сонгуулийн бичиг баримт, техник хэрэгсэл болон сурталчилгааны материал, саналын хуудсыг аймаг, сумын сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх, буцаан татах авах зардал		9,360.0		9,360.0
9	МТБ-ын гишүүний холбоо, унааны зардал		1,250.0		1,250.0
10	Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардал		1,400.0		1,400.0
11	Сонгуулийн байгууллагын ажилтан болон даамал нөөц даамлын тухайн сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал			116,152.8	116,152.8
12	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал			14,820.0	14,820.0
13	Албан томилолтын зардал			6,332.0	6,332.0
14	Шуурхай багийн зардал			4,300.0	4,300.0
<b>Нийт дүн</b>		<b>20,551.0</b>	<b>28,048.0</b>	<b>141,604.8</b>	<b>190,203.8</b>

**Эх сурвалж: Аймгийн сонгуулийн зардлын тайлан**

**1.2.2** Аймгийн сонгуулийн хорооны даргын 3 удаагийн захирамжаар **139,369.6** мянган төгрөгийн санхүүжилтийг сумдын сонгуулийн хороодод хуваарилсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

**Хүснэгт 2. Аймгийн сонгуулийн хорооноос хуваарилсан санхүүжилт /зардлын нэр, төрлөөр/**  
/мянган төгрөг/

№	Зардлын нэр төрөл	2025.05.20	2025.05.30	2025.06.18	Нийт
1	Сонгуулийн дүн мэдээний маягт, албан бичгийн хэвлэмэл хуудас, үнэмлэх хэвлүүлэх зардал	336.0			336.0
2	Сургалтын зардал				-
3	Бичиг хэргийн зардал	2,550.0			2,550.0
4	Шуудан, холбооны зардал	3,400.0			3,400.0
5	Унааны зардал	5,990.0			5,990.0
6	Санал авах байр бэлтгэх зардал		3,000.0		3,000.0
7	Сурталчилгааны зардал		1,700.0		1,700.0
8	Сонгуулийн бичиг баримт, техник хэрэгсэл болон сурталчилгааны материал, саналын хуудсыг аймаг, сумын сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх, буцаан татах авах зардал		4,100.0		4,100.0
9	МТБ-ын гишүүний холбоо, унааны зардал				-
10	Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардал		1,400.0		1,400.0
11	Сонгуулийн байгууллагын ажилтан болон даамал нөөц даамлын тухайн сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал			116,653.6	116,653.6
12	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал				
13	Албан томилолтын зардал			240.0	240.0
14	Шуурхай багийн зардал				
<b>Нийт дүн</b>		<b>12,276.0</b>	<b>10,200.0</b>	<b>116,893.6</b>	<b>139,369.6</b>

**Эх сурвалж: Аймгийн сонгуулийн зардлын тайлан**

**1.2.3** Захирамжийн дагуу аймгийн сонгуулийн хороонд 50,834.2 мянган төгрөг, сумдын сонгуулийн хороонд 139,369.6 мянган төгрөг, нийт **190,203.8** мянган төгрөгийг хуваарилсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

**Хүснэгт 3. Аймаг, сумдын сонгуулийн хороонд олгосон санхүүжилт**

/мянган төгрөг/

№	Сумын нэр	Сумын сонгуулийн хорооны тоо	Санал авах байрны тоо	Төлөвлөгөө	Санхүүжилт	Хэтрэлт/ хэмнэлт
1	Алтанбулаг	2	2	25,101.2	25,101.2	-
2	Баруунбүрэн	1	1	16,209.2	16,209.2	-
3	Жавхланта	1	1	15,669.2	15,669.2	-
4	Орхонтуул	2	2	24,252.4	24,252.4	-
5	Сайхан	2	2	25,631.2	25,631.2	-
6	Сүхбаатар	1	1	16,867.2	16,867.2	-
7	Шаамар	1	1	15,639.2	15,639.2	-
	<b>Сумын дүн</b>	<b>10</b>	<b>10</b>	<b>139,369.6</b>	<b>139,369.6</b>	-
8	Аймаг	1	1	50,834.2	50,834.2	-

Нийт дүн	11	11	190,203.8	190,203.8	-
----------	----	----	-----------	-----------	---

Эх сурвалж: Аймгийн сонгуулийн зардлын тайлан

**1.2.4** Гүйцэтгэлээр сумдын сонгуулийн хороонд төлөвлөгөөний дагуу 139,369.6 мянган төгрөгийн санхүүжилт олгосон боловч Сайхан сумын 2 дугаар хэсэгт санал тэнцэж дахин санал хураалт явуулсан бөгөөд хоолны зардалд 1,100.0 мянган төгрөгийг АСХ-оос нэмж олгосон байна.

### 1.3. Сонгогчийн болон итгэмжлэгдсэн ажилтны тоо, сумдын байршил зэрэг мэдээлэлд үндэслэн зардлын төсвийг хуваарилсан байна.

**1.3.1** УБЕГ-ын даргын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/82 тушаалаар сонгогчийн тоо, итгэмжлэгдсэн ажилтны тоо, сумдын байршил, хоорондын зайг үндэслэн нийт **12,687.5** мянган төгрөгийн санхүүжилтийг Сэлэнгэ аймгийн УБХ-т хуваарилсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

**Хүснэгт 4. УБЕГ-аас аймгийн УБХ-т хуваарилсан санхүүжилт**

№	Зардлын нэр	Батлагдсан төсөв
1	Урсгал санхүүжилт	12,687.5
2	Итгэмжлэгдсэн ажилтны урамшуулал	8,437.5
2.1	Итгэмжлэгдсэн ажилтны урамшуулал	8,437.5
3	Сонгогчийн нэрсийн жагсаалт хэвлэх	3,800.0
3.1	Сонгогчийн нэрсийн жагсаалт хэвлэх болон бусад зардал	3,800.0
8	Сонгуулийн өдөр ажиллах шуурхай багийн зардал	450.0
8.1	Шуурхай багийн зардал	450.0
	Нийт дүн	12,687.5

/мянган төгрөг/

Эх сурвалж: УБХ-ийн зардлын тайлан

## БҮЛЭГ 2. УНААНЫ , АЛБАН ТОМИЛОЛТ, БОЛЗОШГҮЙ, СОНГУУЛИЙН БИЧИГ БАРИМТ БОЛОН ТЕХНИК ХЭРЭГСЛИЙГ АСХ-ООС ХҮЛЭЭН АВАХ, ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ ЗАРДАЛ ЗЭРЭГ ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛЭЭС ШАЛТГААЛАН НИЙТ ЗАРДАЛ 6.4 ХУВИАР ХЭМНЭГДЖЭЭ.

**2.1. УБХ нь аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг бүрэн зарцуулсан байна.**

**2.1.1** СЕХ-ноос Сэлэнгэ аймгийн нөхөн сонгуулийн хорооны төсвийг нийт **190,203.8** мянган төгрөгөөр баталж, хуваарилснаас **178,076.6** мянган төгрөгийг зарцуулж, **12,127.2** мянган төгрөгийг СЕХ-ны дансанд буцаан төвлөрүүлсэн байна. Аймаг, сумдын сонгуулийн хорооны төсвийн гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

**Хүснэгт 5. Аймаг, сумдын сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэл /аймаг, сумдаар/**

/мянган төгрөг/

№	Сумын нэр	Сумын сонгуулийн хорооны тоо	Санал авах байрны тоо	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт/ хэмнэлт
1	Алтанбулаг	2	2	25,101.2	25,074.7	26.5
2	Баруунбүрэн	1	1	16,209.2	16,209.2	-

3	Жавхлант	1	1	15,669.2	15,669.2	-
4	Орхонтуул	2	2	24,252.4	24,252.4	-
5	Сайхан	2	2	25,631.2	25,631.2	-
6	Сүхбаатар	1	1	16,867.2	16,867.2	-
7	Шаамар	1	1	15,639.2	15,639.2	-
	<b>Сумын дүн</b>	<b>10</b>	<b>10</b>	<b>139,369.6</b>	<b>139,343.1</b>	<b>26.5</b>
8	Аймаг	1	1	50,834.2	38,733.5	12,100.7
	<b>Нийт дүн</b>	<b>11</b>	<b>11</b>	<b>190,203.8</b>	<b>178,076.6</b>	<b>12,127.2</b>

*Эх сурвалж: Аймгийн сонгуулийн зардлын тайлан*

**2.1.2** Сумдын нийт дүнгээр төлөвлөсөн зардлыг **26.5** мянган төгрөгөөр хэмнэсэн нь Алтанбулаг сумын урамшууллын зардлаас НДШ-ийг дутуу шилжүүлснээс шалтгаалсан байна.

**2.1.3** Аймгийн сонгуулийн хороо нь нийт төлөвлөсөн зардлыг **12,100.7** мянган төгрөгөөр хэмнэсэн бөгөөд зардлын хэмнэлтэд дараах 4 төрлийн зардал голлон нөлөөлсөн байна. Үүнд:

- **Унааны зардал:** СЕХ-оос өндрөөр төлөвлөж ирсэн, зардлыг гүйцэтгэлээр тооцож олгосон,
- **Сонгуулийн бичиг баримт болон техник хэрэгслийг аймаг нийслэлийн сонгуулийн хорооноос хүлээн авах, хүлээлгэн өгөх зардал:** СЕХ-оос өндрөөр төлөвлөж ирсэн, зардлыг гүйцэтгэлээр тооцож олгосон,
- **Албан томилолтын зардал:** СЕХ-оос өндрөөр төлөвлөж ирсэн, зардлыг гүйцэтгэлээр тооцож олгосон,
- **Болзошгүй зардал:** санал тэнцэж нөхөн сонгууль явагдах магадлалтай гэж үзэн СЕХ-оос өндрөөр төлөвлөж ирсэн, зардлыг гүйцэтгэлээр тооцож олгосон байна.

**2.1.4** Аудитаар аймаг, сумдын сонгуулийн хорооны зардлыг нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, төрийн сангийн дансны хуулгатай тулган шалгахад нийт **621.5** мянган төгрөгийн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

**Сумд:** Дараах 3 сумын сонгуулийн хороо нь унааны зардлыг тооцож олгохдоо батлагдсан нормыг хэтрүүлэн 621.5 мянган төгрөгийг илүү олгосон байна. Энэ нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Автомашинь 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”, сумдын сонгуулийн хорооноос баталсан 100 км гүйлтэд зарцуулах шатахууны нормыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- **Алтанбулаг сум:** Нөхөн сонгуулийн шатахууны зардлыг олгохдоо 86.0 мянган төгрөгийг,
- **Орхонтуул сум:** Нөхөн сонгуулийн шатахууны зардлыг олгохдоо 238.9 мянган төгрөгийг,
- **Сайхан сум:** Нөхөн сонгуулийн шатахууны зардлыг олгохдоо 296.6 мянган төгрөгийг тус тус илүү олгосон,

**2.1.5** УБЕГ-ын даргын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/82 тушаалаар сонгогчийн тоо, итгэмжлэгдсэн ажилтны тоо, сумдын байршил, хоорондын зайг үндэслэн нийт 12,687.5 мянган төгрөгийн санхүүжилтийг Сэлэнгэ аймгийн УБХ-т хуваарилж гүйцэтгэлээр бүрэн зарцуулсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

**Хүснэгт 6. УБХ-ийн зардлын төлөвлөгөө, санхүүжилт, гүйцэтгэл**

/мянган төгрөг/

№	Зардлын нэр	Төлөвлөгөө	Санхүүжилт	Гүйцэтгэл	Хэтрэлт/ хэмнэлт
1	Урсгал санхүүжилт	12,687.5	12,687.5	12,687.5	-
2	Итгэмжлэгдсэн ажилтны урамшуулал	8,437.5	8,437.5	8,437.5	-
2.1	Итгэмжлэгдсэн ажилтны урамшуулал	8,437.5	8,437.5	8,437.5	-
3	Сонгогчийн нэрсийн жагсаалт хэвлэх	3,800.0	3,800.0	3,800.0	-
3.1	Сонгогчийн нэрсийн жагсаалт хэвлэх болон бусад зардал	3,800.0	3,800.0	3,800.0	-
8	Сонгуулийн өдөр ажиллах шуурхай багийн зардал	450.0	450.0	450.0	-
8.1	Шуурхай багийн зардал	450.0	450.0	450.0	-
	<b>Нийт дүн</b>	<b>12,687.5</b>	<b>12,687.5</b>	<b>12,687.5</b>	-

Эх сурвалж: УБХ-ийн зардлын тайлан

**2.1.6** УБХ-ийн сонгуулийн зардлыг нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, төрийн сангийн дансны хуулгатай тулган шалгахад ямар нэгэн зөрчил илрээгүй болно.

## **2.2. Зардлын гүйцэтгэлийг СЕХ-ноос баталсан журмын дагуу тайлагнасан байна.**

**2.2.1** Аймаг, сумдын сонгуулийн хороо нь СЕХ-ны даргын 2025 оны А/33 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын дагуу сонгуулийн зардлын тайланг гаргаж, нэгтгэсэн байна.

**2.2.2** Аймгийн сонгуулийн хорооны нэгтгэж, тайлагнасан төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг зардлын ангиллаар харуулбал:

### **Хүснэгт 7. Сонгуулийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл /зардлын нэр төрлөөр/**

/мянган төгрөг/

№	Зардлын нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт/ хэмнэлт
1	Сонгуулийн дүн мэдээний маягт, албан бичгийн хэвлэмэл хуудас, үнэмлэх хэвлүүлэх зардал	336.0	336.0	(0.0)
2	Сургалтын зардал	1,425.0	1,424.9	(0.1)
3	Бичиг хэргийн зардал	3,150.0	3,149.8	(0.2)
4	Шуудан, холбооны зардал	4,200.0	4,200.0	(0.0)
5	Унааны зардал	11,440.0	7,850.0	(3,590.0)
6	Санал авах байр бэлтгэх зардал	3,000.0	2,999.9	(0.0)
7	Сурталчилгааны зардал	7,000.0	6,700.0	(300.0)
8	Сонгуулийн бичиг баримт, техник хэрэгсэл болон сурталчилгааны материал, саналын хуудсыг аймаг, сумын сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх, буцаан татах авах зардал	15,398.0	13,300.0	(2,098.0)
9	МТБ-ын гишүүний холбоо, унааны зардал	1,250.0	1,250.0	(0.0)
10	Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардал	1,400.0	1,400.0	(0.0)
11	Сонгуулийн байгууллагын ажилтан болон даамал нөөц даамлын тухайн сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	112,649.6	112,412.8	(236.8)
12	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	18,323.2	18,323.2	(0.0)
13	Албан томилолтын зардал	6,332.0	2,760.0	(3,572.0)
14	Шуурхай багийн зардал	4,300.0	1,970.0	(2,330.0)
	<b>Нийт дүн</b>	<b>190,203.8</b>	<b>178,076.6</b>	<b>(12,127.2)</b>

**2.2.3** СЕХ-оос 14 төрлийн зардалд нийт **190,203.8** мянган төгрөгийн төсөв баталж, хуваарилсныг зориулалтын дагуу зарцуулж, үнэн зөв тайлагнасан байна.

**2.3. Аймгийн сонгуулийн хорооноос сумын болон хэсгийн хороодод төсвийн зарцуулалт, тайлагналын талаар сургалт хийж, зөвлөмж хүргүүлсэн байна.**

**2.3.1** СЕХ-ны даргын 2025 оны А/33 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.10-т “... аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хорооны, ... зардлын зарцуулалтад тус тус хяналт тавина” гэж заасан байна.

**2.3.2** Аймгийн сонгуулийн хороо нь СЕХ-ноос ирүүлсэн зөвлөмжийн дагуу сумдын сонгуулийн хороодод нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтыг бүрдүүлэх, санхүүжилтийг арвилан хэмнэлтэй зарцуулах, үнэн зөв тайлагнах, зарцуулалтад хяналт тавих, 2024 оны ИТХ-ын ээлжит сонгуулийн зардлын гүйцэтгэлд төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах зэрэг асуудлаар 1 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулсан байна. Мөн сонгогчдыг сонгуульд идэвхтэй оролцуулах, сонгуулийн мөн чанар, ач холбогдлыг тайлбарлан таниулах чиглэлээр 18-25 насны сонгогчдод зориулан “Хариуцлагатай сонгогч” 5.5 цагийн сургалтыг зохион байгуулж зардлыг санхүүжүүлсэн байна.

**2.3.3** Сумдын сонгуулийн хороодын нягтлан бодогчдын групп үүсгэн, мэдээ, мэдээлэл, үүрэг чиглэл, зөвлөмж өгч, “Сонгуулийн төсвийн зарцуулалтын тухай” зөвлөмжийг бэлтгэн файл хэлбэрээр бүх сумдад хүргүүлсэн байна.

## **АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ**

Аудитаар нийт **621.5** мянган төгрөгийн зөрчил илрүүлж зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүллээ. Үүнд:

### **Зөвлөмж:**

- Нийт 3 сум нь 621.5 мянган төгрөгийг шатахууны тогтоосон нормыг хэтрүүлэн олгож, зарцуулсан байна.

### **ДҮГНЭЛТ**

**Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:**

- Сонгогчийн тоо, сонгууль зохион байгуулахад оролцох ажилтны тоо, сум, хэсгийн хороодын тоо зэрэг мэдээлэлд үндэслэн зардлын төсвийг хуваарилсан байна.
- Сонгогчийн болон итгэмжлэгдсэн ажилтны тоо, сумдын байршил зэрэг мэдээлэлд үндэслэн зардлын төсвийг хуваарилсан байна.
- УБХ нь УБЕГ-аас хуваарилсан санхүүжилтийг СЕХ-ноос баталсан журмын дагуу зарцуулж, тайлагнасан байна.
- Зардлын гүйцэтгэлийг СЕХ-ноос баталсан журмын дагуу тайлагнасан байна.

- Аймгийн сонгуулийн хорооноос сумын болон хэсгийн хороодод төсвийн зарцуулалт, тайлагналын талаар сургалт хийж, зөвлөмж хүргүүлсэн байна.

## **ЗӨВЛӨМЖ**

**Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:**

**Аймгийн сонгуулийн хорооны дарга Ө.Сувдаа, нягтлан бодогч П.Баярцэцэг нарт:**

1. Сумдын сонгуулийн хорооны хуваарилагдсан төсвийн зарцуулалтад үр нөлөө бүхий хяналтыг хэрэгжүүлж, зардлын тайланг хуваарилсан төсөвтэй тулган хүлээж авах,
2. Аймаг, сумдын сонгуулийн хорооноос баталсан автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахууны нормыг мөрдөж ажиллах.

**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ**

**ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ**

**АУДИТОР**



**Б.БАТМӨНХ**

**Ж.БАЯСГАЛАН**

**Э.ЭНХБҮРЭН**

# АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНООС ИРҮҮЛСЭН САНАЛ



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО

213200 Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг  
Утас/Факс: 7036-3966

2025.08.04 № 10  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгууль” зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангийн төсөл болон аудитаас өгч буй зөвлөмжийг хүлээн зөвшөөрч байна. Холбогдох санал үгүй болно.

АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНЫ  
ДАРГА  Ө.СУВДАА

